



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/106

Жавхлант

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчны тухай хуулийн 16.1.1, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 4.10. дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогоор хийгдэх ажилд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Шаравгаваа

ЗДТГ-ын даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

Г.Пүрэвсүх

Хар Ямаат байгалийн нөөц газрын
байгаль хамгаалагч

Гишүүд:

Г.Шижирбаатар

Тархвар зүйч

Х.Аюурзана

Хүүхэд, Гэр бүл нийгмийн ажилтан

Э.Жагдаг

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2. Байгалийн нөөц ашиглалтын орлогоос хийгдэх ажилд хяналт тавьж, тайлан мэдээг хүргэн ажиллахыг Хар Ямаат БНГ-ын байгаль хамгаалагч (Г.Пүрэвсүх)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН